



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/2/СТА-БСД**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Орхон аймаг 2021 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас:70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитор: Т.Болормаа Утас: 70357955 Цахим хаяг:bolormaat@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	0
4 .....	0
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ.....	0
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан .....	1
3.Аудитын тайлан.....	3
3.1. Ерөнхий зүйл.....	3
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	3
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	3
3.4. Материаллаг байдал .....	4
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	4
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	2
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа .....	2
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	5
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
3.10. Аудитын илрүүлэлт.....	6
Залруулсан алдаа.....	6
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	6
4. Менежментийн захидал .....	6
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	8

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.03.15 № 90  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ҮЙЛСБАДРАХ ӨЭМТ-ИЙН  
ДАРГА С.МАНДАХ  
ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх

талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,151,745.08</b>	<b>29,081,974.03</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	175,097.08	101,768.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	175,097.08	101,768.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	175,097.08	101,768.00
31213	Арилжааны банк дахь харилцах	175,097.08	101,768.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	3,458,636.03
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		3,458,636.03
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	14,976,648.00	25,521,570.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	8,736,241.00	11,698,672.00
35110	Тусгай зориулалттай материал	1,578,193.00	1,040,000.00
35130	Эм боох материал	7,158,048.00	10,658,672.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	6,240,407.00	13,822,898.00
35410	Бичиг хэргийн материал	948,710.00	665,910.00
35420	Аж ахуйн материал	5,291,697.00	12,626,288.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	420,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	110,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>50,080,391.94</b>	<b>119,178,809.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	50,080,391.94	119,178,809.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	49,601,558.62	118,856,809.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,750,000.00	45,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,124,999.96)	(20,142,499.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,513,780.00	136,356,887.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,616,675.30)	(59,295,872.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,452,800.00	29,436,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,373,346.12)	(13,098,204.86)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	478,833.32	322,000.00
39301	Програм хангамж	650,000.00	650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(171,166.68)	(328,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>65,232,137.02</b>	<b>148,260,783.64</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>737,598.00</b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	737,598.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	737,598.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	737,598.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	737,598.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>64,494,539.02</b>	<b>148,260,783.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	64,494,539.02	148,260,783.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	31,993,050.00	31,993,050.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	32,022,389.02	115,788,633.64
51210	Өмнөх үеийн үр дүн	28,153,437.97	32,022,389.02
51220	Тайлант үеийн үр дүн	3,868,951.05	83,766,244.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	479,100.00	479,100.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>65,232,137.02</b>	<b>148,260,783.64</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>265,523,082.20</b>	<b>441,244,990.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,445,463.20</b>	<b>98,103,172.48</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,445,463.20	98,103,172.48
120002	Хүүгийн орлого	76,263.20	51,536.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,333,000.00	97,481,636.28
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,541,717.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,633,000.00	2,622,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,700,000.00	91,317,919.28
120009	Бусад орлого	36,200.00	570,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>251,077,619.00</b>	<b>343,141,818.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	201,020,209.00	287,370,313.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,020,209.00	280,345,313.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	7,025,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	50,057,410.00	55,771,505.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	50,057,410.00	55,771,505.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>261,654,131.15</b>	<b>357,478,745.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>261,096,772.89</b>	<b>357,478,745.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	257,397,852.89	347,643,837.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	184,371,042.60	218,694,573.26
210101	Үндсэн цалин	184,371,042.60	218,694,573.26
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,476,425.00	24,511,407.45
210201	Тэтгэврийн даатгал	22,476,425.00	24,511,407.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,015,668.00	1,157,663.00
210301	Гэрэл, цахилгаан	1,015,668.00	1,157,663.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,461,256.00	28,393,665.54
210401	Бичиг хэрэг	7,792,907.00	9,750,230.00
210402	Тээвэр, шатахуун	2,530,000.00	3,690,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,021,296.00	566,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,724,500.00	1,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,392,553.00	602,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	11,844,535.54
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	16,130,248.00	50,150,429.28
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,373,641.00	48,099,206.28
210502	Хоол, хүнс	-	1,028,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,756,607.00	1,022,993.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,393,050.00	1,521,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	110,000.00
210604	Урсгал засвар	2,393,050.00	1,411,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,098,200.00	565,100.00
210702	Дотоод албан томилолт	1,098,200.00	387,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	177,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	941,359.00	2,680,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	581,199.00	1,583,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	652,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	231,660.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	76,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	271,560.00	66,000.00

Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	88,600.00	70,240.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,510,604.29</b>	<b>19,969,239.33</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,562,500.00	192,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,948,104.29	19,777,239.33
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,698,920.00</b>	<b>9,834,908.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,698,920.00</b>	<b>9,834,908.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	809,653.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	685,758.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,889,267.00	9,149,150.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>557,358.26</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>557,358.26</b>	<b>-</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	557,358.26	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>3,868,951.05</u></b>	<b><u>83,766,244.62</u></b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>3,868,951.05</u></b>	<b><u>83,766,244.62</u></b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>267,794,778.20</u></b>	<b><u>352,885,188.82</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,745,463.20</b>	<b>6,786,765.82</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,745,463.20	6,786,765.82
120002	Хүүгийн орлого	76,263.20	51,536.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,633,000.00	6,163,717.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,541,717.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,633,000.00	2,622,000.00
120009	Бусад орлого	36,200.00	571,512.62
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>260,049,315.00</b>	<b>346,098,423.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	209,991,905.00	287,370,313.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,757,807.00	280,345,313.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	8,234,098.00	7,025,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	50,057,410.00	58,728,110.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	50,057,410.00	55,771,505.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		2,956,605.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>261,083,761.00</u></b>	<b><u>349,308,617.90</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>261,083,761.00</b>	<b>349,308,617.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>249,150,743.00</b>	<b>336,517,104.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	184,549,530.00	222,153,209.29
210101	Үндсэн цалин	184,549,530.00	222,153,209.29
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,457,012.00	24,511,407.45
210201	Тэтгэврийн даатгал	22,457,012.00	24,511,407.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,015,668.00	1,157,663.00
210301	Гэрэл, цахилгаан	1,015,668.00	1,157,663.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,164,699.00	23,183,277.00
210401	Бичиг хэрэг	7,595,250.00	9,140,330.00
210402	Тээвэр, шатахуун	2,530,000.00	3,690,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,021,296.00	566,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,724,500.00	1,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,371,973.00	1,799,610.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	921,680.00	6,046,837.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,968,725.00	59,292,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,704,725.00	56,104,450.00
210502	Хоол, хүнс	-	1,455,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	264,000.00	1,732,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,393,050.00	2,219,627.54

Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	2,393,050.00	2,219,627.54
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,098,200.00	387,900.00
210702	Дотоод албан томилолт	1,098,200.00	387,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	941,359.00	3,419,470.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	581,199.00	2,321,098.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	652,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	231,660.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	76,760.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	271,560.00	66,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	88,600.00	71,752.62
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,562,500.00	192,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,562,500.00	192,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,933,018.00</b>	<b>12,791,513.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,933,018.00	12,791,513.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,043,751.00	2,956,605.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	685,758.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,889,267.00	9,149,150.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,711,017.20</b>	<b>3,576,570.92</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,600,000.00</b>	<b>3,649,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,600,000.00</b>	<b>3,649,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,600,000.00	3,649,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,600,000.00	3,649,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(6,600,000.00)</b>	<b>(3,649,900.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	111,017.20	(73,329.08)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	64,079.88	175,097.08
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	175,097.08	101,768.00

## 2.5 ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	31,993,050.00	479,100.00	32,022,389.02	64,494,539.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>31,993,050.00</b>	<b>479,100.00</b>	<b>32,022,389.02</b>	64,494,539.02
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>31,993,050.00</b>	<b>479,100.00</b>	<b>32,022,389.02</b>	64,494,539.02
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>31,993,050.00</b>	<b>479,100.00</b>	<b>32,022,389.02</b>	64,494,539.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>31,993,050.00</b>	<b>479,100.00</b>	<b>32,022,389.02</b>	64,494,539.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			83,766,244.62	83,766,244.62
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>31,993,050.00</b>	<b>479,100.00</b>	<b>115,788,633.64</b>	148,260,783.64

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Үйлсбадрах ӨЭМТ-ийн дарга С.Мандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, шатахуун зарцуулалтын норм тооцох талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 12-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Үйлсбадрах ӨЭМТ нь 2020 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 1-ний өдрийн 4 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд зарим гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэсэн статустай байна.

Үйлсбадрах ӨЭМТ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг анхан шатны эмчилгээ, оношилгоо гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь 2020 онд “Эрүүл мэндийн төвийн үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдэд ээлтэй, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, чирэгдэл хүлээгдэлгүй хүргэж, эрсдэлгүй орчин бий болгох” эрхэм зорилго дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл, мэнд нийгмийн даатгалын тухай хууль.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Үйлсбадрах ӨЭМТ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн хэдий ч мөрдөж буй хууль, журам, дүрэм, стандартын өөрчлөлтийг тусгаагүй байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Засаг даргын СХАА-аас хяналт шалгалт хийгээгүй байна.

Үйлсбадрах ӨЭМТ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлогын 441,244.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,412.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83,028.7 мянган төгрөгөөр буюу 127 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	175.1	101.8	-73.3
Авлага	-	3,458.6	-3,458.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	14,976.6	25,521.6	10,545.0
Үндсэн хөрөнгө	50,080.4	119,178.8	69,098.4
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>65,232.1</b>	<b>148,260.8</b>	<b>83,028.7</b>
Өр төлбөр	737.6	-	-737.6
Эздийн өмч	64,494.5	148,260.8	83,766.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>65,232.1</b>	<b>148,260.8</b>	<b>83,028.7</b>

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 101.8 мянган төгрөг болж 73.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 3,458.6 мянган төгрөг болж 3,458.6 мянган төгрөгөөр өссөн нь ХАОАТ-ын авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,521.6 мянган төгрөг болж 10,545.0 мянган төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотойгоор нэг удаагийн хэрэгслийн нөөц авснаас шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 81,903.6 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүй хүлээн авсан 5,981.5 мянган төгрөгийн эм боох материалын хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 119,178.8 мянган төгрөг болж 69,098.4 мянган төгрөгөөр өссөн нь шинээр худалдан авсан болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 148,260.8 мянган төгрөг болж 83,766.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 31,993.1 мянган төгрөг бөгөөд өсөж, буураагүй байна.
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 479.1 мянган төгрөг бөгөөд өсөж, буураагүй байна.

Хуримтлагдсан ашиг 115,788.6 мянган төгрөг болж 83,766.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийн тооцоог Эрүүл мэндийн яам статистик мэдээнд үндэслэн боловсруулдаг байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Аймгийн Эрүүл мэндийн газар нь төсвийн хуваарь батлаагүй бөгөөд Үйлсбадрах ӨЭМТ нь өөрийн баталсан хуваарийг хянуулж, батлуулаагүй байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 280,345.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 55,771.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 2,622.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,541.7 мянган төгрөг, нийт 339,658.5 мянган төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 4 мэдээллээс 3 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	0.11	1	0.11	100
Албан шаардлага					
Зөвлөмж	5	13.22	5	13.22	100
Нийт дүн	6	13.33	6	13.33	100

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28,296.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 22,679.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 5,616.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан 2,350.3 мянган төгрөгөөр тэнцээгүйг залруулсан.
2. Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн хөрөнгө худалдан авсан 3,649.9 мянган төгрөгийг багаж техник хэрэгсэл дээр буруу тайлагнасныг залруулав.
3. Үр дүнгийн тайлангийн орлого хэсэгт 1,512.62 төгрөгийг илүү илэрхийлснийг залруулсан.
4. Бараа материалд шатахууны урамшууллын орлого 110.7 мянган төгрөг бүртгээгүйг залруулан бүртгүүлсэн.
5. Үр дүнгийн тайлан мөнгөн гүйлгээний тайлангийн цалин 3,842.8 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн дүн 12,724.4 мянган төгрөгөөр буруу илэрхийлснийг залруулсан.

#### Төлбөрийн акт, албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланг хуулийн дагуу тайлагнаж Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй. Сангийн сайдын 388 тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч тайлант онд зөрчил дахин давтагдаж хуулийн хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн тодруулга тайланг бэлтгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна" 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга" заалттай нийцэхгүй, иж бүрэн, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Үйлсбадрах ӨЭМТ-ийн үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, шатахуун зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгөөс ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгө, хөрөнгө дутагдаж илүүдсэн талаар тэмдэглэл үйлдээгүй, үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- 1.2. Эрсдэл: Хөрөнгө дутагдах, ашиглал үүсэх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн тооллогыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу үр дүнтэй зохион байгуулах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 10 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн.

## 2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Кассын тайланд өдөр тутмын шинжилгээний төлбөрийг касс бүртгэдэггүй, касснаас гарсан гүйлгээний бэлэн мөнгөний зарлагын баримтны ард хавсаргасан анхан шатны баримт хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д " Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл: Дотоод хяналт алдагдах.

2.3. Өгсөн зөвлөмж: Кассын ажиллагааны иж бүрэн байдал, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 10 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн.

## 3 Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тайлант онд 3,690.0 мянган төгрөгийн шатахууны гүйлгээ хийсэн байтал анхан шатны баримтаар 3,940.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын тайланд тайлагнасан. Жолоочийн тооцооны хуудсыг хянаж, шатахуун зарцуулалтын тооцоог боддоггүй "note" маркийн тээврийн хэрэгсэл нь 100 км-т 12-30 л шатахуун зарцуулснаар тооцоолсон нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан "шатахуун зарцуулалтын жишиг норм"-той нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл: Дотоод хяналт алдагдах.

2.3. Өгсөн зөвлөмж: Тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын нормыг стандартын дагуу тооцож, шатахуун зарцуулалтын тооцоог бодож, хянаж баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Т.БОЛОРМАА

ОРА-2021/2/СТА-БСД

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ОРА-2021/2/СТА-БСД
Шалгагдсан байгууллагын нэр:	Үйлсбадрах ӨЭМТ		Мян. төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланг хуулийн дагуу тайлагнаж Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй. Сангийн сайдын 388 тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч тайлант онд зөрчил дахин давтагдаж хуулийн хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн тодруулга тайланг бэлтгээгүй.		Албан шаардлага	Үйлсбадрах ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	С.Мандах, Г.Төгөлдөр
2	Үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгөөс ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгө, хөрөнгө дутагдаж илүүдсэн талаар тэмдэглэл үйлдээгүй, үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй.		Зөвлөмж	Үйлсбадрах ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	С.Мандах, Г.Төгөлдөр
3	Кассын тайланд өдөр тутмын шинжилгээний төлбөрийг кассст бүртгэдэггүй, касснаас гарсан гүйлгээний бэлэн мөнгөний зарлагын баримтны ард хавсаргасан анхан шатны баримт хангалтгүй байна	1926.8	Зөвлөмж	Үйлсбадрах ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	С.Мандах, Г.Төгөлдөр
4	Тайлант онд 3,690.0 мянган төгрөгийн шатахууны гүйлгээ хийсэн байтал анхан шатны баримтаар 3,940.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын тайланд тайлагнасан. Жолоочийн тооцооны хуудсыг хянаж, шатахуун зарцуулалтын тооцоог боддоггүй "note" маркийн тээврийн хэрэгсэл нь 100 км-т 12-30 л шатахуун зарцуулснаар тооцоолсон нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан "шатахуун зарцуулалтын жишиг норм"-той нийцэхгүй байна.	3,690.0	Зөвлөмж	Үйлсбадрах ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	С.Мандах, Г.Төгөлдөр
<b>ДҮН</b>		<b>5,616.8</b>			

Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Т.БОЛОРМАА

ОРА-2021/2/СТА-БСД



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 82/82 ОМ 2021/2/СТА-БСД Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланг хуулийн дагуу тайлагнаж Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй. Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч тайлант онд зөрчил дахин давтагдаж хуулийн хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн тодруулга тайланг бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна" 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, Санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үйлсбадрах ӨЭМТ-ийн дарга С.Мандах, нягтлан бодогч Г.Төгөлдөр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ   
АУДИТОР.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР.....  6117143690  
Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.....  Т.БОЛОРМАА